

Албан бус орчуулга

Андрей Бабиш  
БНЧУ-ын Ерөнхий сайд

Прага хот, 2020 оны 7 сарын 2

Эрхэмсэг Танаа,

Таныг Монгол Улсын Засгийн газрын тэргүүнээр дахин томилогдсон явдалд чин сэтгэлээсээ баяр хүргэж буйг минь хүлээн авна уу. Манай хоёр орны нөхөрсөг сайхан харилцааг би маш ихээр хүндэтгэдэг бөгөөд цаашдаа ч хоёр орны хөгжлийн төлөө ашиг сонирхол нэгтэй бүх салбарт хамтран ажиллахдаа бэлэн гэдгээ илэрхийлж байна.

БНЧУ, Монгол улсын хооронд хүн хоорондын хэлхээс түлхүү уламжлалт сайхан харилцаа давамгайлж байдгийг тэмдэглэж хэлэхэд таатай байна. Манай хоёр орны соёлын бодит холбоосыг бий болгож буй олон олон монголчууд БНЧУ-д амьдарч байгаа бөгөөд монгол ажилчид чехийн компаниудад эрэлт хэрэгцээтэй хүмүүсийн тоонд багтдаг. Уламжлалт бөгөөд олон нийтэд ихээхэн таашаагддаг чех-монголын хамтын ажиллагааны нэг хэсэг бол зэрлэг адууны устаж үгүй болох шахаж байсан сүргийг сэргээж Монголын тал нутагт эргүүлэн нутагшуулдаг явдал юм.

Монгол улс COVID-19 цар тахлын тархалтын эсрэг цаг тухайд нь арга хэмжээ авснаар олон хүнд халдварлах нь нас барахаас сэргийлж даван туулж чадсаныг би хүндэтгэлтэйгээр ажиглаж байгаа билээ. Бид харилцан хамтын ажиллагаа, дэмжлэгийнхээ ачаар урьд өмнө байгаагүй өнөө үед дэлхий нийтийг хамарсан хямралыг даван туулж, өөрсдийн харилцаа холбоог дахин өргөжүүлэхэд анхаарлаа хандуулах цаг ирнэ гэдэгт би итгэлтэй байна. Хөдөө аж ахуй, худалдаа, эрчим хүчний салбарт олдож буй боломжуудыг ашиглах чадвартай болно гэж би найдаж байна.

Энэхүү завшааныг ашиглаад Танд удахгүй болох Ардын хувьсгалын ойн баярын мэндийг дэвшүүлж байна. Танд болон танай улсын иргэдэд сайн сайхан, эрүүл энх, ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Эрхэмсэг Танд Монгол Улсын Засгийн газрын тэргүүнээр улиран томилогдсон явдалд дахин баяр хүргэж буйг минь хүлээн авна уу. Танд энэхүү амаргүй бөгөөд хариуцлагатай ажлаа гүйцэтгэх эрч хүчийг ерөөж цаашдын хамтын ажиллагаагаа үр дүнтэй үргэлжлүүлэхдээ баяртай байгаагаа илэрхийлж байна.

Гүнээ хүндэтгэсэн

Эрхэмсэг ноён  
**Ухнаагийн Хүрэлсүх танаа**  
Монгол Улсын ерөнхий сайд

УЛААНБААТАР ХОТ